

**МОНГОЛ УЛСЫН
ТҮҮХ**

2007

ХУВИЛБАР А

НЭГДҮГЭЭР ХЭСЭГ

1. 80000 жилийн тэртээ монгол нутагт хүн амьдарч байсныг нотлох олдворууд хаанаас олдсон бэ? (2 оноо)
А. Хэнтий аймгийн Биндэр сумын Өглөгчийн гол
В. Төв аймгийн Баянцагаан сумын Баян-Айраг
С. Увс аймгийн Улаангом сумын Чандманий соёл
D. Баянхонгор аймгийн Баянлиг сумын Цагаан агуй
E. Сүхбаатар аймгийн Онгон сумын Бүрдийн эрэг
2. 15000-8000 жилийн тэртээх үе ямар зэвсгийн үед хамрагдах вэ? (2 оноо)
А. Неолит
B. Мезолит
C. Палеолит
D. Хүрэл зэвсгийн үе
E. Төмөр зэвсгийн түрүү үе
3. Америкийн угсаатны зүйч, түүхч Морганы онолоор түүхийг хэрхэн хувааж үздэг вэ? (2 оноо)
А. Ураг төрлийн байгуулал, боол эзэмшил, феодализм, капитализм, социализм
B. Зэрлэг үе, бүдүүлэг үе, соёлт үе
C. Ангит нийгэм, ангигүй нийгэм
D. Эртний үе, дунд үе, шинэ үе
E. Эртний үе, завсрын үе, дунд үе, шинэ үе
4. 1691-1911 оны үеийг монголын түүхийн хамгийн гунигт үе гэж үздэг. Үүнтэй холбоогүй өгөгдлийг ол. (2 оноо)
А. Төрийн тусгаар тогтнолоо алдсан
B. Манжийн эрхшээлд орсон
C. Ертөнцөөс тусгаарлагдсан
D. Нийгмийн хөгжлөөс хоцорсон
E. Эдийн засагт шинэчлэл хийгдсэн
5. Монгол нутагт амьдарч байсан эртний хүмүүс нум сумыг хэдий үеэс амьдрал ахуйдаа хэрэглэх болсон бэ? (2 оноо)
А. Неолит
B. Мезолит
C. Палеолит
D. Хүрэл зэвсгийн үе
E. Төмөр зэвсгийн түрүү үе
6. Хан Улс Хүннү гүрэнтэй анх хэдэн онд найрамдлын гэрээ байгуулсан бэ? (2 оноо)
А. МЭӨ 198 он
B. МЭӨ 209 он
C. МЭ 4 8 он
D. МЭ 93 он
E. МЭ 1 89 он
7. Төв аймгийн Батсүмбэр сумын нутаг дахь Ноён уулын булшнаас сарлагийн дүрс, өнгөт зээгт хатгамал ширдэг зэрэг олдвор олдсон нь монгол нутаг дахь эртний улсуудын алинд нь хамаарах вэ? (2 оноо)
А. Хүннү
B. Сяньби (Сүмбэ)
C. Нирун (Жужан)
D. Түрэг
E. Уйгар
8. Зөв харгалзуул. (3 оноо)
1. “Цагаан хэрмээс хойших нь Хүннү Улсын хааны зарлигийг дагатугай, цагаан хэрмээс дотогших түшмэдийн дээл, малгайн улсыг би захирсугай”
a. Модунь шаньюй
2. 330 онд Их Нирун Улсыг байгуулсан
b. Кутулуг
3. Төр улсын үндэс бол газар
c. Хятадын Хан Улсын хаан Лю Бан
4. Улсыг хураагч буюу
d. Мугуйлюй “Эльтерес” цолтой хаан
A. 1d 2c 3a 4b
B. 1a 2d 3b 4c
C. 1b 2a 3c 4d
D. 1c 2d 3a 4b
E. 1c 2d 3b 4a
9. Дараах түүхэн өгөгдлүүдийн аль нь буруу вэ? (2 оноо)
А. МЭӨ 209 онд Модунь шаньюй Хүннүгийн хаан болж улсаа байгуулсан
B. МЭӨ 198 онд Хүннү гүрэн Хан Улстай гэрээ байгуулсан
C. Хүннү гүрэн МЭӨ 209-МЭ193 онд оршин тогтнож байсан
D. МЭӨ 152 онд Хүннү Улс, Хан Улс хоёр хил дээрээ худалдааны зах зээл нээв
E. Хүннү гүрэн улсаа баруун, төв, зүүн гэсэн гурван хэсэгт хуваасан
10. Модунь Шаньюй МЭӨ 192 онд Хан Улсын хатан хаанд “Энх ургийн гэрээ” байгуулья гэсэн утгатай захиа бичжээ. Үүний хариуд Хан Улсын хатан хаан маш их хэмжээний бэлэг сэлтийг Хүннүгийн шаньюйд явуулжээ. Энэ нь ямар зорилготой байсан бэ? Үл хамаарахыг ол. (2 оноо)
А. Хүннүгийн хаан эд баялаг, бэлэг сэлтэд дуртай эсэхийг туршсан
B. Хүннүгийн хаанд найр тавьсан
C. Хүннүгийн довтолгооноос болгоомжилсон
D. Хүннүгийн хааныг басамжилж доромжилсон
E. А ба В зөв

11. Хамаг монгол ханлигийн анхны хаан Хабулын дараа хэн хаан болсон бэ? (2 оноо)
 А. Амбагай В. Хотула С. Есүхэй
 D. Бартан баатар E. Хадаан
12. 1246 онд Тамирын “Шар ордон”-д болсон Их хуралдайгаар хэн их хаанд өргөмжлөгдсөн бэ? (2 оноо)
 А. Өгөдэй В. Хубилай С. Мөнх
 D. Аюушридар E. Гүюг
13. Чингис хаан Хорезмыг дайлаар мордохдоо цэргээ хэдэн хэсэгт хуваасан бэ? (2 оноо)
 А. 1 В. 4 С. 3 D. 5 E. 2
14. Чингис хааны өргөмөл дүү нараас хамгийн түрүүлж есөн өрлөгийн нэг болсон хүн хэн бэ? (2 оноо)
 А. Борохул В. Шихихутуг С. Отчигин
 D. Тэмүгэн E. Аль нь ч биш
15. “Чингис хаан эцгийн зовж байгуулсан улсыг гар газар, хөл хөсөр тавьж жаргуулья” гэсэн үг “Монголын нууц товчоо”-нд тэмдэглэгдсэн байдаг. Энэ үгийг хэн хэлсэн бэ? (2 оноо)
 А. Цагаадай В. Тулуй С. Өгөдэй
 D. Зүчи E. Аль нь ч биш
16. Дараах өгөгдлийг зөв харгалзуул. (2 оноо)
 1. Зүчи a. Дундад Ази дахь монголын хаант Улс
 2. Цагаадай b. Юан гүрэн
 3. Хүлэгү c. Иль хаадын монголын хаант Улс
 4. Хубилай d. Алтан ордны Улс
 А. 1d 2a 3c 4b В. 1d 2c 3a 4b С. 1d 2a 3b 4c
 D. 1c 2d 3a 4b E. 1a 2b 3c 4d
17. Түүхийн судар бичиг, ном зохиолуудад тэмдэглэгдсэн “Гурван голын монголчууд” хэмээх хэллэг байдаг. Энэ нь ямар утгыг илэрхийлдэг вэ? (2 оноо)
 А. Нийт монголчууд В. Язгуурын монголчууд С. Түрэгжсэн монголчууд
 D. Монголжсон түрэг аймаг E. Аль нь ч биш
18. “Монголын нууц товчоо”-нд тэмдэглэгдсэнээр Өгөдэй хаан ширээнд суугаад 4 сайн, 4 муу үйлийг хийлээ гэж хэлсэн байдаг. Өгөдэй хааны хийсэн 4 сайн үйлийг дурьдахдаа илүүц зүйл орсон бол аль нь вэ? (2 оноо)
 А. Алтан улсыг эзлэн дагуулав
 В. Элдэв хэргийг зөөлгөх өртөө замыг тавиулав
 С. Усгүй газар худаг малтуулж гаргуулаад улс иргэнийг ус, өвсөнд хүрэлцээтэй болгов
 D. Зүг зүгийн суурин улсын хотуудад мэдээлэгч, захирагч нарыг тавьж улс иргэнийг амар түвшин болгов
 E. Хүн амын тооллого явуулав
19. 1370-1634 буюу Аюушридаргаас Лигдэн хутагт хүртэлх хаадуудыг нийтэд нь юу гэж нэрлэдэг вэ? (2 оноо)
 А. Бага хаад В. Их хаад С. Сүүлчийн хаад
 D. Завсрын хаад E. Балчир хаад
20. Монголд буддын шашин гурвантаа дэлгэрсэн бөгөөд хоёр дахь дэлгэрэлт Юан гүрний үеийг хамардаг гэж үздэг. Энэ үеийн гол онцлог юу вэ? (2 оноо)
 А. Буддын шашны холбогдолтой олдвор олох төдийгөөр хязгаарлагдсан
 В. Төрийн шашин болж байсан боловч хааны ордны хүрээнд цаашлаад язгууртан ноёдын хүрээнд дэлгэрсэн
 С. Ард түмний ихэнх хэсгийг хамарсан
 D. Юан гүрэн буддын шашныг дэлхий нийтэд дэлгэрүүлж байсан
 E. Аль нь ч биш
21. “Монголын нууц товчоо”-нд тэмдэглэгдсэнээр “Цэр цээжинд, бөөр бөгсөнд байг” гэж ах захтай байх тухай үгийг хэн хэлсэн бэ? (2 оноо)
 А. Алтан В. Хучир С. Тоорил D. Даридай E. Мэнлиг
22. Дараах өгөгдлүүдийг зөв харгалзуул. (2 оноо)
 1. Өгөдэйн ач a. Юан гүрнийг үндэслэн байгуулагч
 2. Тогоонтөмөр b. Хубилай, Аригбөх
 3. Хубилай c. Дүү Аригбөхөд уугуул монгол нутгаа захируулж тамгаа үлдээсэн
 4. Тулуйн хүү d. Хайду ноён
 5. Мөнх хаан e. Юань гүрний сүүлчийн хаан
 А. 1b 2c 3a 4d 5e В. 1a 2d 3c 4b 5e С. 1d 2e 3c 4b 5a
 D. 1d 2e 3a 4b 5c E. 1e 2d 3a 4c 5d

23. Манжийн хаан Энх-Амгалан монгол ноёдын чуулганд оролцож тэдэнд хандан “Та нар бүгд ах дүү нар байж өөр хоорондоо тэмцэлдэн салж бутрахад хүрлээ. Танай олныг өөр засаг хураан авбал халхчууд сөнөх бөлгөө. Иймд миний дотоод, гадаадыг ялгалгүй нэгэн адил өршөөж үзсэн саналыг та нар ухтугай” хэмээн монголыг манжийн харьяат болгон зарлажээ. Энэ үйл явдал хэдэн онд хаана болсон бэ? (2 оноо)
- A. 1767 онд Ховдод B. 1691 онд Долон нуурт C. 1634 онд Хөх нуурт
D. 1700 онд Бээжинд E. Зөв хариулт байхгүй
24. Булган аймгийн Дашинчилэн сумын нутагт “Цагаан байшин” хэмээх өргөө ордны туурь байдаг. Энэ нь өгөгдлийн алинд хамаарагдах вэ? (2 оноо)
- A. Лигдэн хаан B. Галдан бошигт хаан C. Амарсанаа
D. Цогт тайж E. Чингүнжав
25. Манж Чин Улс нь монголчуудын зүгээс гарч болох эсэргүүцлийг номхотгон дарж, өөрийн эрхшээлдээ оруулахын тулд олон арга, бодлогыг явуулжээ. Тэгвэл манжаас монголд явуулж байсан бодлогод үл хамаарахыг ол. (2 оноо)
- A. Шарын шашныг хүчтэй дэлгэрүүлж, олон хутагт хувилгаадыг тодруулж, сүм хийд барих ажлыг идэвхжүүлсэн
B. Монголын зарим ноёдыг өөрийнхөө талд татахын тулд эмс охид өгч ураг холбож, шан харамж өгч байсан
C. Шашныг дэлгэрүүлж, монголчуудын төрд бишрэх үзэл, идэвхийг бууруулахын тулд төрийн хүчирхэг байдлыг ойлгуулсан судар номыг устгах бодлого баримталж, оронд нь шашны судар ном орчуулах ажлыг хөхүүлэн дэмжсэн
D. Монголчуудыг засаг захиргааны хувьд жижиглэн бутаргасан хуваарьт оруулж хүчийг нь саармагжуулсан
E. Монголчуудад гадаад бодлогоо нээлттэй болгох шаардлагыг хүчээр тулган хүлээлгэсэн
26. Манж Чин улсын эрхшээлд байсан монгол түмэн ХҮШ-ХІХ зууны үед төр, шашин, түүхийн оюуны томхон бүтээл, үнэт дурсгалуудыг бий болгожээ. Тэгвэл монгол түмний өөрсдийнх нь бүтээсэн үнэт зүйлсэд үл хамаарахыг нь ол. (2 оноо)
- A. Халх журам хууль B. Болор эрхи C. Алтан товч
D. Соёмбо үсэг E. Гадаад монголын төрийг засах явдлын яамны хууль зүйлийн бичиг
27. Манжийн эрхшээлийн сүүл үеийн “Шашин төрөө бататган газар орноо хамгаалж амар суух цаг ирэв. Бидний юу хийхийг харж хүлээж буй хөөрхий монголчуудын чухал үйл явдлыг саатуулж үл болно. Та нар юу санаж явдагаа надад дуулга” гэсэн нууц лүндэнг хэн буулгасан бэ? (2 оноо)
- A. Д.Сүхбаатар B. Жалханз хутагт Дамдинбазар
C. Богд Жавзандамба D. Өндөр гэгээн Занабазар
E. Магсаржав хурц
28. 1919 оны 11-р сарын 20-нд Сүй Шүй Жан генерал цэргийн хүчээр монголд орж ирээд юун түрүүнд авсан арга хэмжээ юу вэ? (2 оноо)
- A. Улсын, дээд доод хурлыг шинэчлэн байгуулсан
B. 1915 оны 3-н улсын гэрээг цуцалж, автономит эрхийг цуцалсан
C. 64 зүйлийн гэрээг боловсруулсан сайд, ноёдыг шагнасан
D. Дээд хурлаар “Их Монгол Улс” байгуулах тухай асуудлыг хэлэлцсэн
E. Богдын хааны эрхийг сэргээсэн
29. 1911 онд Богд Жавзандамба хутагтыг хаан ширээнд өргөмжлөхөд олгосон цол (2 оноо)
- A. Гэгээн B. Бошгот C. Нарангэрэлт, түмэн наст
D. Хатан зоригт E. Түмэн хишигт, гэгээн оюунт
30. Ховдын хязгаарын “Цэцэг нуурын хөдөлгөөн” гэж алдаршсан манжийн ноёрхол, ноёд түшмэдийг эсэргүүцсэн тэмцлийг удирдагч хэн бэ? (2 оноо)
- A. Энхтайван B. А.Аюуш C. Онолт
D. Тогтох тайж E. Сумьяа бэйс
31. Монгол нутагт тариа тариулах, уурхай нээж ашигт малтмал олдворлох, шуудан харилцаа байгуулах, хужир давс ашиглах, төмөр зам тавих, сургуулийн танхим байгуулах, банк нээх, дээрэм хулгайг арилгах зэргийг хэрэгжүүлэхийг гол удирдамж болгосон баримт бичиг аль нь вэ? (2 оноо)
- A. Шинэ эргэлтийн бодлого B. Шинэ засгийн бодлого
C. Анхдугаар таван жилийн төлөвлөгөө D. Улс орны хөгжүүлэх хэтийн төлөвлөгөө
E. Эдийн засгийг хөгжүүлэх үндсэн бодлого, чиглэл
32. 1919 оны II сард японы санаачилга дэмжлэгтэйгээр буриад, барга, Өвөр монголын үндсэрхэг үзэлтэй зарим түшмэд болон Оросын шинэ засаг төрд дургүйцэн бослого гарган нутгаасаа дүрвэсэн генерал Г. М. Семеновыг өдөөж “Их Монгол Улс” байгуулах асуудал хэлэлцсэн газар аль нь вэ? (2 оноо)
- A. Манжуур B. Чита C. Хиагт D. Долон нуур E. Нийслэл хүрээ

33. Хүн төрөлхтний хөгжлийн замыг "... авирах гишгүүртэй, нэгээс үүсэн дэвших ба усан дор гүн орохтой утга адил буй" хэмээн тодорхойлж уг замаар Монгол орныг хөгжүүлэх эрмэлзэлтэй байсан улс төрийн зүтгэлтнийг нэрлэ. (2 оноо)
 А. Д. Бодоо В. Д.Сүхбаатар С. Япон Данзан
 D. Солийн Данзан E. X.Чойбалсан
34. Анхдугаар их хурлаас Улсын бага хурлын гишүүнээр 30 хүн сонгосны дотор ЗСБНХУ-ын харьяат хэдэн хүн байсан бэ? (2 оноо)
 А. 5 В. 10 С. 1 D. 2 E. 3
35. БНМАУ-ын Бага хурлын төлөөлөгчид, Ардын сайд нарын зөвлөлийн хамтарсан хурлаас баталсан "Онцгой бүрэн эрхт комисс"-ыг 3 хүнтэй батлав. Зөвийг ол (2 оноо)
 А. X.Чойбалсан, Д.Лувсаншарав, А.Амар В. Д.Лувсаншарав, Г.Цэрэндорж, А.Амар
 С. X.Чойбалсан, Г.Цэрэндорж, М.Ф.Чибисов D. X.Чойбалсан, Г.Цэрэндорж, Д. Лувсаншарав
 E. X.Чойбалсан, А.Амар, М.Ф.Чибисов
36. 1939 оны эцсээр X.Чойбалсан Сталинтай уулзахдаа улс орны цаашдын хөгжлийн талаар зөвлөгөө өгөхийг хүсчээ. Сталин МАХН-ын Төв Хорооны сургагчаар нэгэн хүнийг илгээсэн бөгөөд тэр хүн намын шинэ програм, дүрмийн төслийг авч ирсэн. Энэ хүн хэн байв. (2 оноо)
 А. В. Молотов В. Ю. Проходов С. Л. Берия
 D. Чобяк E. Голубчик
37. Г.Содном, Пүрэв, С.Немой, Киковский, Жамсран, Самбуу, Ж.Лхүмбэ - эдгээр түүхэн зүтгэлтнүүдийн үйл ажиллагаанд дүгнэлт өгч доорх өгөгдлөөс хамгийн оновчтой нэг ойлголтыг сонго. (2 оноо)
 А. Монгол дахь 1921 оны үндэсний ардчилсан хувьсгал
 B. Монгол дахь эдийн засгийн өөрчлөлт
 C. Монгол дахь зэвсэгт бослого
 D. Монгол дахь соёлын хөгжил
 E. Монгол дахь улс төрийн зөв бодлого
38. Монголын эх оронч хөвгүүдээс "Би монгол хүний саруул ухаанд итгэдэг" гэж хэн хэлсэн бэ? (2 оноо)
 А. Д.Сүхбаатар В. С.Зориг С. О.Дашбалбар
 D. М.Зэнээ E. Ц.Элбэгдорж
39. 1921 оны 11 сард Судар бичгийн хүрээлэн байгуулагдсан. Хожим хэдэн онд Шинжлэх ухааны хүрээлэн болсон бэ? (2 оноо)
 А. 1930 он В. 1940 он С. 1925 он D. 1932 он E. 1924 он
40. 1959 оны эхээр хуралдсан МАХН-ын Төв Хорооны III бүгд хурлаас доорх шийдвэрийг гаргав. Зөв утгыг ол. (2 оноо)
 А. Улс орноо 5 жилийн төлөвлөгөөтэй хөгжүүлэх В. Атар газрыг эзэмших
 C. Ардын ахуйтныг хоршоололд нэгтгэх D. Өртөөний албыг улсын болгох
 E. Сонгуулийг ардчилсан болгох
41. 1941 онд Сайд нарын зөвлөлийн дэргэд улаан армид бэлэг хуримтлуулах ажлыг эрхлэн зохион байгуулах бэлэглэлийн төв комиссыг байгуулав. Энэ байгууллагын явуулж байсан үйл ажиллагааны баримтаас алдааг ол. (3 оноо)
 А. "Бүгдийг фронтод", "Бүхнийг ялалтын төлөө" уриан дор ажиллав
 B. Ард түмнээс цуглуулсан анхны бэлгийн цувааг 1942 оны 11 сард илгээв
 C. 1943 онд 54 танкнаас бүрдсэн "Хувьсгалт монгол" танкийн цуваа, 12 онгоцноос бүрдсэн "Монгол ард" нисэх онгоцны эскадрилийг шилжүүлэв
 D. Зөвлөлт эх орны дайны жилүүдэд монголын ард түмэн улаан армид 60 орчим сая төгрөгийн бэлэг явуулжээ
 E. 1942 онд малчин ардууд 104 мянган агт худалдаж, 32 мянгыг бэлэглэсэн юм
42. 1921 онд Монгол улсын зах зээлд эргэлдэж байсан доорх мөнгөн тэмдэгтүүдээс бурууг ол. (2 оноо)
 А. Орос В. Мексик С. Америк D. Хятад E. Төгрөгийн дэвсгэрт
43. 1921 оны 8-р сард Улсын түр цагийн хурал байгуулагдав. Уг хурал ард, цэрэг, түшмэл, ноёд зэрэг хэдэн хүний бүрэлдэхүүнтэй байсан бэ? (2 оноо)
 А. 48 В. 56 С. 51 D. 58 E. 60
44. 1921 оны 8-р сард байгуулагдсан Улсын түр цагийн хурал нь ямар эрхтэй байгууллага байсан бэ? (2 оноо)
 А. Засгийн газрын бодлогыг хязгаарлах байгууллага
 B. Засгийн газрын бодлогыг хэрэгжүүлэх байгууллага
 C. Засгийн газарт зөвлөх байгууллага
 D. Засгийн газартай хамтран ажиллах байгууллага
 E. Эдгээрээс өөр эрх мэдэлтэй байгууллага

45. Коминтерн нь олон улсын коммунист, хувьсгалт, ажилчны намын үйл ажиллагааг удирдан зохион байгуулж, социалист хувьсгалыг ялалтад хүргэх үүрэг зорилготой байгууллага байв. Буруу ойлголтыг ол. (2 оноо)
- A. 1919 оны 3-р сард Москвад байгуулагдсан
 - B. 1943 оны 5-р сард үйл ажиллагаа нь зогссон
 - C. 1920 оны намраас МАН холбоо тогтоосон
 - D. Монгол улсын нам төрийн үйл ажиллагаанд шууд хутгалдан орсон
 - E. Монгол улсын хөгжлийн урт хугацааны хэтийн төлөвлөгөөг боловсруулсан
46. Үнэ чөлөөлөх анхны зоримог алхмыг Д. Бямбасүрэнгийн засгийн газар хэдийд хийсэн бэ? (2 оноо)
- A. 1990 оны 12-р сар 21-р тогтоол
 - B. 1991 оны 1-р сар 20-р тогтоол
 - C. 1993 оны 3-р сар 10-р тогтоол
 - D. 1992 оны 5-р сар 12-р тогтоол
 - E. 1993 оны 5-р сар 15-р тогтоол
47. Дараах өгөгдлүүдээс Л.Н.Гумилевын хэлсэн үгийг сонго. (2 оноо)
- A. “Угсаатнаас ангид соёл, соёлоос ангид угсаатан гэж үгүй”
 - B. “Монголчууд өөрсдөө нэхий, даалимба өмсч, номоо торгоор боодог ард түмэн”
 - C. “Номгүй айл сэтгэх тархигүй биетэй адил”
 - D. “Номын засаг үгүй болвоос амьтад тамд унах, хааны засаг үгүй болвоос улс аймаг эвдрэх больюу”
 - E. “Ном бол аливаа шан талархлыг үл горилогч багш мөн”
48. “Шинэ эргэлтийн бодлого”-ын жилүүдэд зүүнтний уршгаар бий болсон хямралыг даван туулж, эдийн засаг соёлын хөгжилд тодорхой ахиц гарч, ард түмний аж байдал дээшлэн, хөдөлмөрлөх урам зориг нэмэгдсэн ажээ. Гэвч ... Дараах өгөгдлөөс зөвийг ол. (2 оноо)
- A. Шинэ эргэлтийн бодлого 1930-аад онд хязгаарлагдсан
 - B. Шинэ эргэлтийн бодлого 1930-аад онд таслагдсан
 - C. Шинэ эргэлтийн бодлого 1930-аад оны II хагасаас хязгаарлагдсаар тасрав
 - D. Шинэ эргэлтийн бодлого 1930-аад оноос цааш хөгжсөн
 - E. Эдгээрээс өөр
49. “Хир буртаг өчүүхэн ч хүргэхгүй нандигнан хайрлаж, тахиж шүтэж байх зүйл маань нэгдүгээрт нийгмийн өмч, хоёрдугаарт социалист өмчийг цогцлон бүрдүүлэгч эх үүсвэр болсон ариун цагаан хөдөлмөр мөн”. Үүнийг уншаад социалист нийгмийн үнэлэмжид тохирохгүйг ол. (2 оноо)
- A. Бага балчираасаа туйлын арвич хямгач байх
 - B. Социалист өмчийг алхам тутамдаа нүдлэн хамгаалагч байх
 - C. Хөдөлмөрийг бишрэн шүтэгч байх
 - D. Хувийн өмчийг дээдлэн, өмч өмчлөх ба эзэмших
 - E. Хувийн өмчийг үзэн ядаж, хавчин гадуурхах
50. 1992 онд Монгол Улсын шинэ Үндсэн хууль батлагдсанаар монголд эрх зүйт төр төлөвшиж, эрх мэдлийн тэнцвэртэй харилцаа бий болох нөхцөл бүрдсэн. Дараах өгөгдлийн зөв хариулт аль нь вэ? (2 оноо)
- A. Монгол Улсын ерөнхий сайд засгийн газрыг тэргүүлэгч бөгөөд шүүгчийг томилно
 - B. УИХ-ын дарга дангаараа ямар ч хуулийг, ямар ч үед батлах, цуцлах эрхтэй
 - C. Хууль зүйн сайд хууль батлах эрхтэй
 - D. Монгол Улсын Ерөнхийлөгч төрийн тэргүүн, монголын ард түмний эв нэгдлийг илэрхийлэгч бөгөөд уучлал үзүүлэх эрхтэй
 - E. УИХ хууль тогтоох эрхтэй бөгөөд уучлал үзүүлэх эрхтэй
51. 1971 онд Монгол Улсаас төрсөн анхны дэлхийн аварга тамирчин хэн бэ? (2 оноо)
- A. Ж.Мөнхбат - чөлөөт бөх
 - B. З.Ойдов - чөлөөт бөх
 - C. Д.Дэмбэрэл - байт сур
 - D. Ш.Чанарав - самбо бөх
 - E. Х.Баянмөнх - чөлөөт бөх
52. Ардын засгийн газар улс орноо цагаантны цэргээс бүрэн чөлөөлөх явдалд онцгой анхаарал тавьж 3 чиглэлээр тулалдаан хийжээ. Барон Унгерн, Резухин, Сундуй гүн, Сухарев нарын хүчийг бут цохисон тулалдаан аль нутагт болсон бэ? (3 оноо)
- A. Вангийн хүрээ, Заяын хүрээ, Жалханзын хүрээ, Хөвсгөлийн Тариалан
 - B. Сэлэнгийн Алтанбулаг, Хиагт, Тужийн нарс
 - C. Сагсайн хүрээ, Бага Харгай, Толбо нуур, Саруул гүний хүрээ
 - D. Ховд хот, Улиастай хот
 - E. Молцог элс, Шивээлэг уул, Сан бээсийн хүрээ
53. Хаант Орос улсын туслалцаатайгаар байгуулагдсан цэргийн сургуульд монгол цэргийн анхны бага дарга нарыг бэлтгэж байсан. Энэ сургууль хаана байгуулагдсан бэ? (2 оноо)
- A. Улиастай
 - B. Хиагт
 - C. Ховд
 - D. Хужирбулан
 - E. Алтанбулаг

54. Орчин үед төрийн бодлогын хамгийн нарийн нандин нууцыг Монгол улсын ерөнхийлөгчийн тэргүүлсэн “Үндэсний аюулгүй байдлын зөвлөл” чандлан хадгалдаг. Уг зөвлөлд доорх албан тушаалтнуудын аль нь орох вэ? (2 оноо)
- А. Ерөнхийлөгч, УИХ-ын гишүүд
 В. Ерөнхийлөгч, Засгийн газрын гишүүд
 С. Ерөнхийлөгч, Тагнуулын төв газрын удирдлага
 D. Ерөнхийлөгч, Ерөнхий сайд, УИХ-ын дарга
 E. Ерөнхийлөгч, Засгийн газрын гишүүд, УИХ-ын гишүүд
55. Монголын түүхийн талаарх сурвалжуудыг зөв харгалзуул. (2 оноо)
- | | | |
|-----------------|--------------------------------|----------------|
| 1. Марко Поло | a. Судрын чуулган | |
| 2. П.Карпини | b. Дорно этгээдэд зорчсон минь | |
| 3. Г.Рубрук | c. Монголчуудын түүх | |
| 4. Рашид ад Дин | d. Орчлонгийн элдэв сонин | |
| A. 1d 2c 3b 4a | B. 1a 2d 3b 4c | C. 1a 2c 3b 4d |
| D. 1c 2b 3d 4a | E. 1c 2b 3d 4a | |
56. 1912 оны 1-р сарын 12-нд Улиастай хотыг, мөн оны 8-р сард Ховд хотыг манж хятадын дарлалаас чөлөөлөх тулалдаанд гавъяа байгуулсан хүмүүст Богд хаан цол хэргэм хүртээсэн байна. Зөв өгөгдлийг ол. (2 оноо)
- А. Сүхбаатар, Чойбалсан
 В. Магсаржав Дамдинсүрэн
 С. Цэрэнчимэд, Ханддорж
 D. Хайсан, Сумъяа бээс, Сундуй гүн
 E. Гомбо Идшин, Сундуй гүн
57. Социализмын үеийн онцлогт тохирохгүй өгөгдлийг ол. (2 оноо)
- А. Нэг хүнийг тахиж шүтэх үзэл дэлгэрсэн
 В. Нэг намын үзэл суртал ноёрхож байсан
 С. Нийгмийн хөгжлийн жам ёсны жишгээр хөгжсөн
 D. Хувийн өмчийг илт гадуурхаж байсан
 E. Хүний үзэл бодлыг хязгаарлаж байсан

ХОЁРДУГААР ХЭСЭГ

- 2.1. Манж улс 1728 онд монгол аймгуудын чуулганд нэр өгч, чуулж байх газрыг нь тогтоож өгчээ. Дараах өгөгдлийг 2.1-д зөв харгалзуул. (А, В, С, D, E тус бүрд харгалзах утгыг 1, 2, 3, 4, 5-аас сонгоно уу). (5 оноо)
- | | |
|-------------------------------|-------------------------------|
| А. Түшээт хан аймаг | 1. Цэцэрлэгийн чуулган |
| В. Сэцэн хан аймаг | 2. Хан уулын чуулган |
| С. Засагт хан аймаг | 3. Хэрлэн барс хотын чуулган |
| D. Сайн ноён хан аймаг | 4. Биндэрьяа нуурын чуулган |
| E. Далай хан, Үнэн зоригт хан | 5. Баруун, зүүн гарын чуулган |
- 2.2. Хубилай хааны үед бичсэн “Дөрвөн төрийн арван буянт номын цагаан түүх” -д: “Өндөр талбарт сэнтий - хүнд суудлын бэлгэ, хашхираа ихт улаан бүрээ - хамгаас хүндэтгэхийн бэлгэ” гэжээ. Доорх өгөгдлүүдийг 2.2-д зөв харгалзуул. (А, В, С, D, E тус бүрд харгалзах утгыг 1, 2, 3, 4, 5-аас сонгоно уу). (5 оноо)
- | | |
|---------------------------|---------------------------------|
| А. Хараа ихтэй хар туг | 1. Төр тогтоохын бэлгэ |
| В. Ээл ихт хүнд бүс | 2. Засаг явуулахын бэлгэ |
| С. Цогт ихт шар шүхэр | 3. Бусдыг айлгахын бэлгэ |
| D. Зангараг ихт алмас илд | 4. Найз нар, арга билгийн бэлгэ |
| E. Түшиг сайн өрлөгүүд | 5. Олноо өргөгдөхийн бэлгэ |

ХУВИЛБАР С

НЭГДҮГЭЭР ХЭСЭГ

1. Доорх өгөгдлүүдийн зөв харгалзааг тогтоо. (2 оноо)
1. Палеолит а. Дунд чулуун зэвсгийн үе
2. Мезолит б. Шинэ чулуун зэвсгийн үе
3. Неолит с. Хуучин чулуун зэвсгийн үе
- A. 1a 2c 3b B. 1b 2d 3a C. 1b 2a 3c D. 1b 2c 3a E. 1c 2a 3b
2. Палеолитийн үеийн хамрагдах хугацаа аль нь вэ? (2 оноо)
- A. 800000-15000 B. 15000-8000 C. 8000-3000
D. 100000- 40000 E. 40000-15000
3. Палеолитийн дунд үед дэлхий дахиныг хамарсан их мөстлөг болсноор хүний амьдралд олон өөрчлөлт гарсан. Үүнтэй холбоогүй өгөгдлийг ол. (2 оноо)
- A. Хөдөлмөрийн багаж зэвсэг B. Хоол хүнс C. Хувцас, орон сууц
D. Хүний бие, оюун санаа E. Бүгд зөв
4. Монгол нутагт газар тариалангийн аж ахуй үүсэж, хөгжсөнийг илтгэх олдворт аль нь багтах вэ? (2 оноо)
- A. Өмнөговь аймгийн Булган сумын Баянзаг
B. Төв аймгийн Баян-Өнжүүл сумын Үнэгт
C. Увс аймгийн Улаангом сумын Чандманий соёл
D. Баянхонгор аймгийн Баянлиг сумын Цагаан агуй
E. Сүхбаатар аймгийн Онгон сумын Бүрдийн эрэг
5. 40000 жилийн өмнө амьдарч байсан оюун ухаант хүнийг юу гэж нэрлэдэг вэ? (2 оноо)
- A. Хомо сапиенс B. Хомо эректус C. Архайк хомо сапиенс
D. Хомо хабилис E. Хомо сапиенс сапиенс
6. Монгол Нирун (Жужан) Улс хэдийд оршин тогтнож байсан бэ? (2 оноо)
- A. 745-840 B. 552-745 C. 330-555
D. 307-581 E. Зөв хариулт алга
7. Уйгарын нийслэл Балыклик (Хар балгас) хотын туурь өнөөгийн Монгол Улсын аль нутагт байдаг вэ? (2 оноо)
- A. Өвөрхангай аймаг, Бүрд сум B. Архангай аймаг, Хотонт сум
C. Хөвсгөл аймаг, Ар булаг сум D. Булган аймаг, Сайхан сум
E. Сэлэнгэ аймаг, Мандал сум
8. Хаадын цолыг улсуудтай нь зөв харгалзуул. (2 оноо)
1. Шаньюй а. Түрэг
2. Зонхилогч (толгойлогч хаан) б. Сяньби (Сүмбэ)
3. Эльтерес (улсыг хураагч) c. Уйгар
4. Тэнгэрээс заяагч, төр засагч мэдэлтэй хаан d. Хүннү
- A. 1d 2a 3b 4c B. 1b 2c 3d 4a C. 1b 2a 3c 4d
D. 1a 2b 3c 4d E. 1d 2b 3a 4c
9. Дараах өгөгдлийг зөв харгалзуул. (2 оноо)
1. Тоба улс а. Галт буу, шатар
2. Хүннү б. Руни бичиг
3. Кидан c. Гал, нар, сар бүхий төрийн сүлд
4. Түрэг d. Гөрмөл гээзэгтэн
- A. 1a 2c 3b 4d B. 1b 2d 3a 4c C. 1d 2a 3c 4b
D. 1d 2c 3a 4b E. 1c 2b 3d 4a
10. Шэлүнь хаан түүх, газар зүй, одон орон, зурхайн ухаан, бурхан шашны ном зохиол судалдаг хүн байсан нь эрт цагт Азид соёл, шинжлэх ухааны үр хөврөлүүд эрчимтэй явагдаж байсны тод жишээ юм. Шэлүнь аль улсын ямар цолтой хаан байсан бэ? (2 оноо)
- A. Монголын “Их хаан” B. Хятадын Хан Улсын “Эзэн хаан”
C. Их Нирун Улсын “Хутагтай цэцэн хаан” D. Түрэгийн “Улсыг хураагч хаан”
E. Зөв хариулт байхгүй
11. Их хуралдай зарлаж Чингис хааны гутгаар хүү Өгөдэйг хаан ширээнд өргөмжилсөн байдаг. Их хуралдай хаана, хэзээ болсон бэ? (2 оноо)
- A. 1229 онд Хэрлэнгийн Хөдөө арал B. 1228 онд Сэлэнгийн Буур хээр
C. 1230 онд Тамирын Шар Ордонд D. 1227 онд Хар зүрхний Хөх нуурт
E. 1229 онд Дэлүүн болдогт

12. Дараах өгөгдлийг зөв тохируул. (2 оноо)
- | | | |
|----------------|--|----------------|
| 1. Черби | a. Өдрийн манаа | |
| 2. Хорчин | b. Цэргийн асуудал эрхлэгч | |
| 3. Хэвтүүл | c. Шөнийн манаа | |
| 4. Тайш | d. Ордны дотоод асуудал хариуцсан даамал | |
| A. 1d 2a 3b 4c | B. 1b 2c 3d 4a | C. 1b 2a 3c 4d |
| D. 1a 2b 3c 4d | E. 1d 2a 3c 4b | |
13. 1241-1246 онд Их Монгол Улсын төрийг барьснаар алтан ургийнхны хагарлыг хурцатгасан гэж зарим судлаачид үздэг хатны нэр хэн бэ? (2 оноо)
- | | | |
|-------------------|--------------|------------|
| A. Сохагтани Бэхи | B. Дөргэнэ | C. Данхунд |
| D. Огуль Каймиш | E. Баабуужин | |
14. Чингис хаан шадар хишигтэн цэргийг байгуулж мянгат, түмтийн зэрэг ноёдыг томилохдоо юуг эрхэмлэж байсан бэ? (2 оноо)
- | | |
|-------------------------|-----------------------------------|
| A. Итгэл даах чадвараар | B. Цэвэр цусан төрлийн холбоогоор |
| C. Удам угсаагаар | D. Гавьяа зүтгэлээр |
| | E. А болон D зөв |
15. Чингис хааны үеийн төрийн зүтгэлтнүүдийн нэр цолыг зөв харгалзуул. (2 оноо)
- | | | |
|----------------|----------------|----------------|
| 1. Гоо ван | a. Шихихутуг | |
| 2. Их зайран | b. Үсүн өвгөн | |
| 3. Их заргач | c. Хөхчү | |
| 4. Их төлөгч | d. Мухулай | |
| A. 1d 2a 3b 4c | B. 1d 2c 3a 4b | C. 1a 2c 3b 4d |
| D. 1b 2d 3a 4c | E. 1d 2c 3b 4a | |
16. Чингис хааны төрийн 4 их хатны төрсөн аймгийг зөв харгалзуул. (2 оноо)
- | | | |
|----------------|------------------------|----------------|
| 1. Бөртэ | a. Хонгирад | |
| 2. Хулан | b. Татар | |
| 3. Есүй | c. Мэргид | |
| 4. Есүгэн | d. Хэрэйд | |
| A. 1d 2a 3b 4c | B. 1d 2c 3a 4b | C. 1a 2c 3b 4b |
| D. 1b 2d 3a 4c | E. Зөв хариулт байхгүй | |
17. Өнөөгийн Сэлэнгэ аймгийн нутгийн орчим XII-XIII зууны үед ямар аймаг оршиж байсан бэ? (2 оноо)
- | | | |
|------------------|-----------|------------|
| A. Хамаг монгол | B. Татар | C. Жадаран |
| D. Гурван мэргид | E. Хэрэйд | |
18. Баруун монголчуудаас “Их хаан” ширээнд сууж байсан цөөн хаадуудын нэг бөгөөд тайш байхдаа 20000 цэрэг удирдан Мин улсын 500000 цэргийг бут цохиж, хаанаар нь хонь хариулуулж байсан хүн хэн бэ? (2 оноо)
- | | | |
|----------------|------------------|-----------|
| A. Тогоон тайш | B. Эсэн тайш | C. Тайсун |
| D. Хадаан тайш | E. А болон В зөв | |
19. Шарын шашин монгол оронд дэлгэрснээр эерэг болон сөрөг нөлөөг монголчуудад үзүүлсэн гэж үздэг. Сөрөг нөлөөг дурьдахдаа илүүц зүйл дурьдсан бол аль нь вэ? (2 оноо)
- | |
|--|
| A. Монголчууд хүлцэнгүй болж, эртний дайчин чанараа алдсан |
| B. Төрд итгэх үзлийг саармагжуулсан |
| C. Түүх соёлын гайхамшгууд бий болсон |
| D. Хүн амын өсөлт зогссон |
| E. Илүүц зүйл байхгүй |
20. Монголын уран зохиолын дээж бичгүүдийн нэг “Убаши хун тайжийн тууж” хэмээх зохиолд монголын түүхийн аль үеийг харуулдаг вэ? (2 оноо)
- | | |
|------------------------------|-----------------------|
| A. Эртний улсуудын үе | B. Их Монгол Улсын үе |
| C. Улс төрийн бутралын үе | D. Манжид эзлэгдэх үе |
| E. Манжийн эрхшээлд орсон үе | |
21. 1604-1634 онд хаан ширээнд сууж байсан Лигдэн хааны цол юу вэ? (2 оноо)
- | | | | | |
|----------|-----------|----------|---------|---------|
| A. Сэцэн | B. Хутагт | C. Далай | D. Тайш | E. Даян |
|----------|-----------|----------|---------|---------|
22. Манж Чин Улс Халх монголд анх 7 хошуу байсныг түүхийн явцад хэд хэдэн удаа жижигрүүлж багасгасан. Тэгвэл 1691 онд Монгол Улс хэдэн хошуутай болсон бэ? (2 оноо)
- | | | | | |
|------|-------|-------|--------|--------|
| A. 8 | B. 34 | C. 74 | D. 120 | E. 250 |
|------|-------|-------|--------|--------|
23. Ар монголд байгуулсан Манж Чин Улсын хамгийн дээд эрх бүхий байгууллага аль нь вэ? (2 оноо)
- | | |
|-----------------------------|---------------------------|
| A. Улиастайн жанжны газар | B. Их хүрээний сайдын яам |
| C. Ховдын манж сайдын газар | D. А, В, С хариулт зөв |
| E. Зөв хариулт байхгүй | |

24. Манжийн хааны “Төмөр сүрэг” төвлөрч байсан гол нутгийг ол. (2 оноо)
А. Дарьганга В. Хүрээ С. Улиастай
D. Ховд E. Төмөр сүрэг гэж байгаагүй
25. Түшээт хан Гомбодоржийн хүү “Өндөр гэгээн” хэмээн түүхэнд алдаршсан Занабазар нь шашин, соёлын нэрт зүтгэлтэн төдийгүй уран бүтээлч хүн байлаа. Түүний бүтээлд үл хамаарах өгөгдлийг ол. (2 оноо)
А. Ооёмбо үсэг В. Цутгуурын урлаг С. Ногоон, цагаан дарь эх
D. Хэвтээ дөрвөлжин бичиг E. Халх журам хууль
26. Ар монголыг хятадын харьяаны автономит эрхтэй улс байлгах, Өвөр монгол, Баруун монголыг хятадын харьяаны ерийн муж байлгах аар тогтсон баримт бичиг аль нь вэ? (2 оноо)
А. Тангаргийн гэрээ В. 64-н зүйлийн гэрээ С. Гурван гүрний хэлэлцээр
D. Монгол-Оросын хэлэлцээр E. Зарлигаар тогтоосон Монгол Улсын хууль зүйлийн бичиг
27. “Шинэ засгийн бодлого”-ыг монголд хэрэгжүүлэхээр 1910 онд Их хүрээнд томилогдон ирсэн манж сайд хэн бэ? (2 оноо)
А. Сү Чен Ван В. Чен И С. Саньдо
D. Да Шэн Куй E. Тянь Идэ
28. Богд хаант Монгол Улсын Бүгд ерөнхийлөн захирах яамыг байгуулмагц ерөнхий сайдаар хэнийг томилсон бэ? (2 оноо)
А. М. Ханддорж В. Г. Цэрэнчимид С. Д. Бодоо
D. Т. Намнансүрэн E. С. Данзан
29. 1911 оны Үндэсний эрх чөлөө тусгаар тогтнолын төлөөх хувьсгалын удирдагчдыг ол. (2 оноо)
А. Д.Цэрэнчимэд В. Д.Бодоо С. М.Хандорж
D. Жавзандамба хутагт E. А С, D зөв
30. Богд Жавзандамба хутагтыг Төр шашныг хослон барих, хэмжээгүй эрхт хаанд өргөмжлөх ёслол хэдийд болсон бэ? (2 оноо)
А. 1912.12.29 В. 1911.11.20 С. 1913.01.24
D. 1911.12.29 E. 1912.07.13
31. 1915 оны “Гурван гүрний гэрээ”-нд талуудын баримталж буй асуудалд хамааралгүй нь аль нь вэ? (2 оноо)
А. Төрийн тусгаар тогтнолоо хүлээн зөвшөөрүүлэх
В. Монголыг хятадын харьяаны ерийн муж байлгах
С. Хятадын харьяанд автономит эрхтэй байлгах
D. Баруун монгол, Өвөр монголыг хятадын харьяаны ерийн муж байлгах
E. Гурван улсын хилийн дээсийг сэргээн шинэчлэх
32. Ц.Лоохууз, Б.Нямбуу, Б.Сурмаажав нар МАХН-ын 1964 оны ҮI бүгд хурал дээр ямар зорилго чигийг баримталж байсан бэ? (2 оноо)
А. Социализмын нилээд ардчилсан, илүү үндэсний загвар
В. Намын эсрэг үзэлтний байр суурь
С. Намыг хагалан бутаргах үйл ажиллагаа
D. Бүлэглэсэн явууллагын үйлдэл
E. Намын удирдлагыг гартаа авахыг санаархсан
33. 1934.11.10-нд Коминтерний хурал дээр тэрээр хэлэхдээ: “Монгол бол стратегийн асар чухал ач холбогдолтой. Түүнээс гадна, монгол бидний хувьд түүхий эдийн талаас томоохон ач холбогдолтой юм. ... 800000 хүн амтай энэ орныг бид хямдхан авч болно” гэж хэн хэлсэн бэ? (2 оноо)
А. П.М.Никифоров В. Б.Шмераль С. И.Райтер
D. М.Амагаев E. Б.Шумяцкий
34. 1932 оны 4-р сард Очирбатын яамыг байгуулж түүнийг Залан Жамсран гэгч толгойлж байжээ. Ийнхүү босогчид удирдах төвтөй болсон бөгөөд тэд өөрсдийгөө юу гэж нэрлэж байв? (2 оноо)
А. Шарын цэрэг В. Шашныг мандуулагчид С. Шамбалын цэрэг
D. Номхотгон дарагч E. Шашны цэрэг
35. Богд хаан, ДИУ-ын салшгүй хэсэг, Э.Ринчино, ЗСБНХУ, Худалдаа аж үйлдвэрийн банк, Мал эмнэлгийн ажилтны түр сургууль, Ардын гэгээрүүлэх яам, Сүхбаатарын нэрэмжит клуб эдгээр түүхэн ойлголтуудад дүгнэлт өгч доорх он цагуудаас холбогдох нэгийг сонго. (2 оноо)
А. 1921 он В. 1922 он С. 1928 он
D. 1924 он E. 1925 он
36. Хэний тэргүүлсэн засгийн газрын үед дэд бүтцийн гол тэнхлэг дагуу авто зам барих ажлыг “Мянганы уриан дор эхэлсэн бэ? (2 оноо)
А. Р.Амаржаргал В. М.Энхсайхан С. Н.Энхбаяр
D. Г.Элбэгдорж E. Ж.Наранцацралт

37. Хүрээний ба Консулын бүлгэмийнхэн 1920 оны 06-р сарын 25-нд С.Данзангийн гэрт хамтран хуралдаж гаргасан түүхэн шийдвэр аль нь вэ?
 А. ЗОУ-аас тусламж хүсэх төлөөлөгчдийг томилсон
 В. Ноёдын бүлгэмтэй холбоо тогтоохоор тохирсон
 С. Ардын журамт цэрэг байгуулахаар шийдсэн
 D. Үндэсний ардчилсан хувьсгалыг эхлүүлэхээр шийдсэн
 E. Гадаад Монголын автономит эрхийг сэргээсэн
38. 1945 оны 10-р сарын 20-нд ямар үйл явдал болсон бэ? (2 оноо)
 А. Хятадын засгийн газар манай улсын тусгаар тогтнолыг хүлээн зөвшөөрөв
 В. БНМАУ, Дундад Иргэн Улсын хооронд дипломат харилцаа тогтов
 С. Төрийнхөө тусгаар тогтнолыг баталж гарын үсэг зурав
 D. БНМАУ, БНХАУ-тай дипломат харилцаа тогтоов
 E. Монгол-Хятадын найрамдлын хэлэлцээр байгуулагдав
39. Улсын ҮИ их хурлаар “Төр ба шашныг тусгаарлан явуулах тухай хууль”-ийг шинэчилжээ. Энэ хуулийн заалтад байхгүй зүйлийг ол. (2 оноо)
 А. Жасын малыг болзолтойгоор ардуудад өгч маллуулах
 В. Худалдаа хийх эрхийг нь хязгаарлах
 С. Албан татвар авах
 D. Хавчин хязгаарлах бодлого барих
 E. Сүм хийдийн холбогдолтой хуулиудыг хэвээр үлдээх
40. Хувьсгалын дараа монголд хувийн худалдааг хавчих, улс хоршооллын худалдааг дэмжих бодлогыг коминтерний заавраар явуулав. Монголд Центросоюз, Сибгосторг, Дальгосторг зэрэг зөвлөлтийн худалдааны байгууллагууд ажиллах болов. Холбогдох оныг ол. (2 оноо)
 А. 1921 он В. 1922 он С. 1923 он D. 1924 он E. 1922 оны сүүлчээс
41. Ардын засгийн газар Богд хааны эрхийг хязгаарлан тогтоосныг хууль эрхийн үндэстэй болгосон ямар дүрмийг хэдийд баталсан бэ? (2 оноо)
 А. 1921.9.1 Зөвшлийн гэрээ В. 1921.11.1 Тангаргийн гэрээ
 С. 1921.10.1 Эвслийн гэрээ D. 1921.12.1 Хамтын гэрээ
 E. 1921.11.5 Хэлэлцээрийн гэрээ
42. 2002 оны 6-р сарын 28-нд “Монгол улсын иргэнд газар өмчлүүлэх тухай” хууль батлагдаж, уг хуулиар гэр бүлийн хэрэгцээнд зориулж дурьдсан хэмжээний газрыг өмчлүүлэх болсон. Зөвийг ол. (2 оноо)
 А. Нийслэлд 0.07 га, аймгийн төвд 0.5 га, сумын төвд 0.6 га
 В. Нийслэлд 0.04 га, аймгийн төвд 0.75 га, сумын төвд 0.3 га
 С. Нийслэлд 0.07 га, аймгийн төвд 0.35 га, сумын төвд 0.5 га
 D. Нийслэлд 0.05 га, аймгийн төвд 0.45 га, сумын төвд 0.4 га
 E. Нийслэлд 0.06 га, аймгийн төвд 0.8 га, сумын төвд 0.7 га
43. “Харц ард эзэн үгүй яахин явах ... хааны нэгэн үрд харьяалагдах буюу” хэмээн түүхэнд бичжээ. Уг сурвалжийг уншаад өгөгдлөөс зөв дүгнэлтийг сонго. (2 оноо)
 А. Эзэн харьяатын ёс үүсэн бий болсон В. Эзэн харьяатын ёс туйлдаа хүрсэн
 С. Эзэн харьяатын ёс устаж үгүй болсон D. Эзэн харьяатын ёс огт байгаагүй
 E. Дээрх бүгд буруу
44. Дараах өгөгдлөөс Чингис хаан алийг нь хэлээгүй вэ? (2 оноо)
 А. “Миний нутгийн газар шорооноос бурхан гуйсан ч битгий өг”
 В. “Эх нутгийнхаа төлөө тэмцэхээс өөр ариун эрхэм нандин нэр төр гэж байна уу?”
 С. “Эх орон аюулд орсон цагт өмгөөлөн босохоос татгалзах эрх хэнд ч байхгүй”
 D. Алийг нь ч хэлээгүй
45. Ардын засгийн газраас 1923.07.24-нд үндэсний эдийн засгийг хөгжүүлэх үзэл баримтлал бүхий 18 зүйлтэй баримт бичгийг боловсруулан гаргажээ. Тэр баримт бичгийн нэр юу вэ? (2 оноо)
 А. “Эдийн засгийн хөгжлийн зорилго” В. “Эдийн засгийн үндсэн бодлого чиглэл”
 С. “Эдийн засгийн үндсэн бодлого” D. “Эдийн засгийн хөтөлбөр”
 E. Бүгд буруу
46. “БНМАУ-ын зорилго бол социализмыг төгөлдөр байгуулж, цаашдаа коммунист нийгэм байгуулах явдал мөн” энэ тодорхойлолтыг дараах өгөгдөлд тохируулж зөвийг ол. (2 оноо)
 А. 1924 оны Үндсэн хууль
 В. 1940 оны Үндсэн хууль
 С. 1960 оны Үндсэн хууль
 D. 1992 оны Үндсэн хууль
 E. Аль нь ч биш МАХН-ын бичиг баримт

47. Монголд эрх зүйт төр төлөвших эх үндэс нь хэдийд яаж тавигдсан бэ? Зөвийг ол. (2 оноо)
А. 1921 оны Үндэсний ардчилсан хувьсгалаар
В. 1960 оны Үндсэн хуулиар
С. 1990 оны Өөрчлөлт шинэчлэлээр
D. 1992 оны Үндсэн хуулиар
E. 1989 оны Ардчилсан холбооны анхны чуулганаар
48. Ардын намын цэргийн тоо түргэн өргөжиж Алтанд ирж хуарагнав. Газар бүрээс ирсэн тэдгээр цэргийг 4 хэсэг болгожээ. Тэгвэл Түшээт хан аймгийн Эрдэнэ вангийн хошуунаас элсүүлсэн хүмүүсийг юу гэж нэрлэсэн бэ? (2 оноо)
А. Шадар цэрэг
В. Хошуу цэрэг
С. Цахар цэрэг
D. Цоохор цэрэг
E. Бүгд буруу
49. Японы эсрэг дайнд Монгол ардын хувьсгалт цэрэг Х. Чойбалсангийн удирдлаган дор ЗХУ-ын маршал Р.Я. Малиновскийн командалсан өвөр Байгалийн фронтын цэргийн хамт ямар үндсэн 2 чиглэлээр давшсан бэ? (3 оноо)
А. Долон нуур, Жэхэ, Чуулалт хаалга
В. Долон нуур, Жэхэ
С. Жэхэ, Чуулалт хаалга
D. Манжуур, Жанчхүү
E. Манжуур, Чуулалт хаалга
50. Бакич, Казанцев, Кайгородов нарын удирдсан цагаантнуудтай хийсэн тулалдаан хаана болсон бэ? (3 оноо)
А. Баянцагаан, Халх гол
В. Хиагт, Алтан булаг, Тужийн нарс
С. Молцог элс, Шивээлэг уул, Сан бэйсийн хүрээ
D. Сагсайн хүрээ, Бага Харгай, Толбо нуур, Саруул гүний хүрээ, Улаангом
E. Вангийн хүрээ, Заяын хүрээ, Хөвсгөлийн Тариалан, Жалханзын хүрээ
51. Одоогийн Улаанбаатар зочид буудлын суурин дээрх нэгэн байшинд Монгол Улсын Анхдугаар Их Хурал хуралджээ. Уг хуралтай холбогдох ойлголтыг тэмдэглэ. (2 оноо)
А. Тангаргийн гэрээ
В. Орос-Монголын найрамдлын гэрээ
С. Үндсэн хууль
D. Намын нөхдийн дагаж мөрдөх “Тангаргийн бичиг”
E. Монгол ардын намын баримт бичиг
52. Монгол Улсын их хурлаас 2006 оны 7-р сарын 6-нд батлагдсан “Төрийн бэлгэ тэмдгийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хууль”-нд заасны дагуу Монгол Улсын төрийн дууллын үгийг шинэчилсэн бөгөөд мөн өдрөөс дагаж мөрдөх болов. Энэ бадагт огт өөрчлөгдөөгүй мөрийг ол. (2 оноо)
Дархан манай тусгаар улс
Даяар монголын ариун голомт
Далай их дээдсийн гэгээн үйлс
Дандаа энхжиж, үүрд мөнхөжнө
А. 1, 2-р мөр
В. 2, 3-р мөр
С. 3, 4-р мөр
D. 1-4-р мөр
E. 2, 4-р мөр
53. Манжийн төрөөс монголд хятадын аль мужаас худалдаачин цэрэг ирэхэд тохиромжтой эсэх, төмөр зам байгуулбал хаанаас залгавал зохих зэргийг судлан тодорхойлж байсны эцсийн зорилго юу вэ? (2 оноо)
А. Монгол улсад дэд бүтэц хөгжүүлэх
В. Хүн амын амьдралын түвшинг дээшлүүлэх
С. Монголын байгалийн баялгийг хятад руу зөөх
D. Монголыг хятадын нэг муж болгох
E. Дээрх бүгд буруу
54. Монголчууд монгол бичгийг шинэтгэн сайжруулах үндсэн дээр түүнд тулгуурласан олон бичиг үсгийг зохион хэрэглэж байсан. Доорх өгөгдлүүдээс зөвийг ол. (2 оноо)
А. Али гали, тод, вагиндра
В. Соёмбо, хэвтээ дөрвөлжин
С. Дөрвөлжин, соёмбо, али гали
D. Тод, вагиндра, кирилл
E. Галиг, тод соёмбо
55. Хувьсгалт нууц бүлгийн 7 гишүүн 1920 оны 8-р сард нууцаар ээлж дараагаар ЗОУ-ын Эрхүү хотод очиж, Оросын Коммунист (большевик) намын нөхөдтэй уулзаж туршлага солилцсон явдал хувьсгалын цаашдын үйл хэрэг өрнөхөд чухал түлхэц болов. Тэд ажил үүргийн хуваарь гарган 3 хэсэг болж ажиллав. ЗОУ-ын удирдах хүмүүстэй уулзаж тусламж хүсэх хэлэлцээ хийхээр Москва руу хэн хэн явсан бэ? (2 оноо)
А. Сүхбаатар, Чойбалсан
В. Догсом, Бодоо
С. Лосол, Данзан, Чагдаржав
D. Дугаржав, Бодоо
E. Данзан, Догсом, Лосол
56. 1921 оны Үндэсний ардчилсан хувьсгал гарахад нөлөөлсөн хүчин зүйлд аль нь хамаарахгүй вэ? (2 оноо)
А. Монголын төр мөхөж, тусгаар тогтнолоо алдсан
В. Мөнгөний ханш унаж, хятад худалдаачдын мөлжлөг ширүүссэн
С. Улс оронд тогтворгүй байдал бий болсон
D. Манжийн төрийн харгис бодлого хэрэгжиж эхэлсэн
E. Эсэргүүцэл тэмцэл, үймээн самуун гарах болсон

57. Богд хаант Монгол Улсын төрөөс соёл боловсролд түлхүү анхаарч ард олноо гэгээрүүлэх, өсвөр үеийг сургууль соёлд хамруулах, сургах талаар зарим ажил хийж эхэлсэн байна. Дараах өгөгдлийг зөв харгалзуул. (2 оноо)
- | | | |
|--|--------------------|-------------------|
| 1. Анхны бага сургууль | a. 1918 он | |
| 2. Шинэ толь сэтгүүл | b. 1913 он | |
| 3. Нийслэлийн сонин бичиг | c. 1912 он | |
| 4. Зарлигаар тогтоосон Монгол Улсын шаштир | d. 1915 он | |
| A. 1d, 2c, 3b, 4a, | B. 1a, 2d, 3b, 4c, | C. 1a, 2c, 3b, 4d |
| D. 1d, 2b, 3c, 4a, | E. 1c, 2b, 3d, 4a, | |

ХОЁРДУГААР ХЭСЭГ

- 2.1 1921 оны үндэсний ардчилсан хувьсгалтай холбогдолтой дараах түүхэн он цаг, үйл явцыг 2.1-д зөв харгалзуул. (А, В, С, D, E тус бүрд харгалзах утгыг 1, 2, 3, 4, 5-аас сонгоно уу). (5 оноо)
- | | |
|------------------|---|
| A. 1921.IX.10-12 | 1. Тусгаар тогтнолоо зөвшөөрүүлэх нот бичгийг ЗОУ, АНУ болон дэлхийн бусад улсад илгээв |
| B. 1922.I сар | 2. Орос-Монголын хооронд найрамдалт харилцаа тогтоох тухай хэлэлцээрт гарын үсэг зурав |
| C. 1921.VIII сар | 3. Богд хааны эрхийг хязгаарласан хууль эрхийн үндэстэй “Тангаргийн гэрээ” дүрэм батлав |
| D. 1921.XI.1 | 4. Гаалийн шинэ дүрэм батлав |
| E. 1921.XI.5 | 5. Худалдааны пүүс ба үйлдвэрийн эздээс татвар хураах дүрэм мөрдөгдөв |
- 2.2 Манж Чин улсын эрхшээлд байсан монгол түмэн ХҮШ-ХІХ зууны үед төр, шашин, түүхийн оюуны томхон бүтээл, үнэт дурсгалуудыг бий болгожээ. Дараах өгөгдлийг 2.2-д зөв харгалзуул. (А, В, С, D, E тус бүрд харгалзах утгыг 1, 2, 3, 4, 5-аас сонгоно уу). (5 оноо)
- | | |
|---------------------|---|
| A. Халх журам хууль | 1. Өндөр гэгээн |
| B. Цутгуурын урлаг | 2. Рашипунцаг |
| C. Гангын урсгал | 3. Гүн Гомбожав |
| D. Болор эрхи | 4. Түшээт хан аймгийн засаг ноён Дондовдорж нарын монгол ноёд |
| E. Алтан товч | 5. Мэргэн гэгээн |

2007 оны Монгол улсын түүхийн хичээлийн даалгаврын түлхүүр

Нэгдүгээр хэсэг		
№	Хувилбар А	Хувилбар С
1	D	E
2	B	A
3	B	E
4	E	E
5	B	A
6	A	C
7	A	B
8	D	E
9	C	D
10	D	C
11	A	A
12	E	C
13	B	B
14	A	E
15	C	B
16	A	C
17	B	D
18	E	B
19	A	C
20	B	C
21	C	B
22	D	B
23	B	A
24	D	A
25	E	E
26	E	C
27	C	C
28	B	D
29	C	E
30	B	D
31	B	E
32	B	A
33	D	B
34	D	A
35	D	D
36	B	C
37	B	A
38	B	C
39	A	E
40	B	C
41	B	B
42	E	C
43	B	B
44	C	D
45	E	C
46	B	C
47	D	D
48	D	B

№	Хувилбар А	Хувилбар С
49	D	A
50	D	D
51	C	C
52	A	E
53	D	D
54	D	A
55	A	C
56	B	D
57	C	E

Хоёрдугаар хэсэг				
	Хувилбар А		Хувилбар С	
	2.1	2.2	2.1	2.2
a	2	4	1	4
b	3	1	5	1
c	4	3	4	3
d	1	2	3	2
e	5	5	2	5

